Нүүрсний нийт хэмжээг урьд онтой харьцуулахад 2022 онд 306,139 тонн, 2023 онд 399,951 тонн буюу 93,812 тонноор нэмэгдэж 23.4%-иар нэмэгдүүлэн татан авалт хийсэн. Дулаан үйлдвэрлэлд зарцуулсан нүүрсний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 22.4%-иар өссөн байна.

### ДОТООД ХЭРЭГЦЭЭНД ЗАРЦУУЛСАН ДУЛААН


Дотоод хэрэгцээнд 14,459 Гкал дулааны эрчим хүч зарцуулахаар төлөвлөж, 13,017 Гкал-ыг зарцуулж, 1,442 Гкал ДЭХ-ийг бага зарцуулсан



### ЖИШМЭЛ ТҮЛШНИЙ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ

Нэгж		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
Жишмэл түлшний хувийн зарцуулалт төлөвлөгөө	кг/Гкал	162.6	162.6	162.26	162.09	163.32	164.10	163.18	162.95	162.67	162.86
Жишмэл түлшний хувийн зарцуулалт биелэлт	кг/Гкал	163.85	167.61	163.54	161.66	163.17	169.18	166.99	169.38	164.15	164.9

### 2023 оны жишмэл түлшний хувийн зарцуулалт кг/Гкал



Үзүүлэлт	Нэгж	2022 он	2023 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Кг/Гкал	168	162.86	164.90	2.04	3.1

2023 онд 162.86 кг/Гкал жишмэл түлшний хувийн зарцуулалттай ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэлээр 164.9 кг/Гкал жишмэл түлшний хувийн зарцуулалттай байна.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2.04 кг/Гкал-аар илүү гарсан нь дараах шалтгаануудаас хамааралтай. Үүнд:

Нүүрсний илчлэг төлөвлөгөөнөөс 50–260 кг/ккал-аар бага ирснээс жишмэл түлшний хувийн зарцуулалт 2.041 кг/Гкал-аар илүү гарсан. 2023 оны 10 сард Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн уурхайд соляркны хомдол үүссэний улмаас 10 хоног үйл ажиллагаа нь доголдсон. Үүнээс шалтгаалан Амгалан Дулааны станцад нийлүүлэх нүүрсийг урьдчилан цагаалга хийх боломжгүй болж чийгтэй нүүрс ачиж явуулах болсноор илчлэг 100-260 кг/ккал-аар бага ирэх болсон. Үүний улмаас жишмэл түлшний хувийн зарцуулалт нэмэгдсэн. Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-ийн уурхайн нүүрсний илчлэгээс хамаарч 5893тн нүүрс илүү зарцуулсан.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулан төлөвлөж гүйцэтгэлийг сар бүр хуваарийн дагуу жилийн хугацаанд 6100 вагон буюу 399,951.38 тонн нүүрс татан авч нөөц бүрдүүлэв. Тайлант онд нийт 386,097.2 тонн нүүрс зарцуулж 35,439 тонн үнс гаргаж, үнслэгийн хэмжээ жилийн дунджаар 9.3% байна. Нүүрсний агуулах нь 14000 тоннын багтаамжтай. Нүүрсний битүү агуулахын хэмжээ бага байгаагаас 23,750 тонн нүүрсийг нөөцлөх зорилгоор захиргааны байрны хойно шинээр талбай засаж 8000 тонн нүүрс, 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугам доор 3000 тонн нүүрс нөөцөлсөн. Энэ нөөцлөгдсөн нүүрс нь манай станцын 20 хоногийн нүүрсний нөөцийг бүрдүүлсэн. Харин өвлийн ачааллаар тооцвол 8-10 хоногийн нөөцтэй байна.

### ЗАРЦУУЛСАН НҮҮРС, ҮНСНИЙ ХАРЬЦАА

Үзүүлэлт	Хэмжигч нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жилээр
Нүүрсний зарцуулалт	Тонн	71953.7	56100	48469.5	35065.7	5958.7	6750	30800	56000	75000	386097.2
Үнсний хэмжээ	Тонн	8415.3	3926	3461	3622	442	427	3012.7	4687	7446	35439
Үнслэгийн хувь	Хувь	11.6	6.9	7.1	10.3	7.4	6.3	9.7	8.3	9.9	9.3

### СҮЛЖЭЭНИЙ УСНЫ ЗАРЦУУЛАЛТ




2023 онд дунджаар сүлжээний усны зарцуулалтыг 2,928 тн/цагаар төлөвлөж, зарцуулалтыг 2,882 тн/цагаар барьж ажилласан. 2023 онд сүлжээний усны зарцуулалтыг 46 тн/цагаар бууруулсан байна.

2023 оны 10, 11, 12-р сард төлөвлөгөөнөөс 8.9-9.6%- иар буурсан байна.

Үзүүлэлт	Нэгж	2022 он	2023 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Сүлжээний усны зарцуулалт	тонн/цаг	2552	2928	2882	98.4%	112,9%

2023 – 2024 оны халаалтын улиралд Улаанбаатар хотын оргил ачааллын үеийн нийлбэр сүлжээний усны зарцуулалт 25,780 тонноос Амгалан дулааны станц ТӨХК-ийн сүлжээний усны зарцуулалт 4,460 тонн хүрснээр 17.3%-ыг эзэлж байна.

### НЭМЭЛТ УСНЫ ЗАРЦУУЛАЛТ



2023 онд сүлжээнд 225,591 тонн нэмэлт ус нэмэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 177,736 тонныг зарцуулж, төлөвлөснөөс 47,855 тонн нэмэлт ус бага зарцуулсан.

Үзүүлэлт	Нэгж	2022 он	2023 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Нэмэлт усны зарцуулалт	Тонн	135048	225591	177736	47855	42688

### СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ


2023 онд зуухны суурилагдсан хүчин чадлын ашиглалт дундажаар 55,65% байсан байна. 2023 онд суурилагдсан хүчин чадлын оргил ачаалал 12-р сард буюу 90,01% хүрсэн бол хамгийн бага ачаалал нь 9-р сард 19,22% ачаалалаар ажилласан байна.

Зуухны нийт ажилласан хугацаа 13015 цаг

Нэг зуухны хамгийн их тасралтгүй ажилласан хугацаа нь 4644 цаг




### ЗУУХНЫ АЖИЛЛАСАН ЦАГ



2023 онд тасралгүй удаан ажилласан зуух №2 цаг, хамгийн их цаг буюу 4,644 цаг ажилласан байна.

### ЗУУХНЫ АЖИЛЛАСАН БАЙДАЛ



### ДҮТ ТӨХХК-ИАС ӨГСӨН ГОРИМЫН БИЕЛЭЛТ

Үзүүлэлт	Нэгж	1 сар	2 сар	3 сар	4 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Жил-ээр
Температурын горим	°C	121/60	114/53	99/48	88/46	87/46	90/49	100/51	120.1/57.9	102.3/51.3
Температурын гүйцэтгэл	°C	121.9/55.9	116.4/53.6	102.3/48.1	95.41/43.91	86.98/46.03	90.49/45.90	107.04/51.16	120.0/56.3	105.0/50.1
Даралтын горим төлөвлөгөө	ата	8.5/2.0	8.5/2.0	8.5/2.0	8.3/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.4/2.0	8.0/2.0	7.9/2.0
Даралтын горим гүйцэтгэл	ата	8.5/2.0	8.5/2.0	8.5/2.0	8.3/2.0	7.0/2.0	7.0/2.0	7.4/2.0	8.0/2.0	7.9/2.0
Сүлжээний усны зарцуулалт төлөвлөгөө	Тонн/цаг	3861	3436	3194	2667	1400	2650	3830	4300	3578
Сүлжээний усны зарцуулалт гүйцэтгэл	Тонн/цаг	3861	3436	3194	2667	1358	2380	3469	4136	2881

2023 оны хамгийн их ачаалал 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гадна агаар -32 градус хүрсэн үед сүлжээний усны зарцуулалт 4460 тн/ цаг, үйлдвэрлэсэн дулаан цагт 303,2 Гкал/цаг, суурилагдсан хүчин чадал ашиглалт 101.1% хүрч ажилласан байна.

### ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

2023 онд 36,510.9 МВт цахилгаан эрчим хүч зарцуулах төлөвлөгөөнөөс 37,133.2 МВт цахилгаан эрчим хүч зарцуулсан байна. 2022 онд 29,040.83 МВт цахилгаан хэрэглэж, өмнөх оноос 8093.3 МВт цахилгааныг илүү зарцуулсан нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ 21.8%-иар нэмэгдсэн байна.



**Цахилгааны хэрэглээ /2022-2023 он/**

Сар	2022 Гүйцэтгэл /Мвт/	2023 Төлөвлөгөө /Мвт/	2023 Гүйцэтгэл /Мвт/	Зөрүү/Өмнөх онтой харьцуулсан/
1	5,071.17	6,437.20	6,437.28	1,366.11
2	4,609.34	5,308.10	5,308.30	698.96
3	3,435.89	4,577.97	4,576.42	1,140.53
4	1,970.07	3,695.00	3,693.71	1,723.64
5	70.17	780.8	780.8	710.63
6	38.98			
7	33.91			
8	46.82			
9	904.351	765.83	765.83	-138.521
10	2,515.92	3,256.60	3,343.12	827.2
11	4,536.81	4,965.00	5,209.96	673.15
12	5,807.40	6,724.40	7,017.75	1,210.35
<b>Дүн</b>	<b>29,040.83</b>	<b>36,510.90</b>	<b>37,133.17</b>	<b>8,092.34</b>

Үзүүлэлт	Нэгж	2022 он	2023 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц-өм.он
Цахилгааны зарцуулалт	Мян.кВт.ц	29040	36510	37133	4.2%	27.8%
Цахилгааны хувийн зарцуулалт	%	34.2	35.3	35.8	0.5	1.6

**3.3. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ  
ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР**

Аюулгүй ажлын байр бий болгох, эрүүл ахуйн нөхцлийг хангах, байгаль орчныг хамгаалах, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг ХАБЭА-аас гаргасан дотоод журмуудын хэрэгжилтэнд хяналт тавих, заавар зөвлөмж өгөх зорилгоор ХАБЭА-н I, II шатны үзлэгт хяналт тавьж ажилласан. Амгалан дулааны станцын цех, хэлтэс, хэсгийн ажлын байруудад эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, эрүүл ахуйн нөхцлийг хангах,

техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавих, заавар зөвлөмж өгөх зорилгоор Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу улирал бүр Хөдөлмөрийн аюулгүй байдлын III шатны үзлэгийг явуулсан. Зөрчлийг тухай бүр нь арилгуулж ажилласан.

**А. ЭЭЛЖИТ ЗААВАРЧИЛГАА**

№	Агуулга	Зааварчилгаа авсан ажилтны тоо
1	Урьдчилсан зааварчилгаа	161
2	Анхан шатны зааварчилгаа	28
3	Зочидын зааварчилгаа	310
4	Сарын давтан зааварчилгаа	820
5	Тухайлсан зааварчилгаа	790
Нийт		2109

**Б.ЭЭЛЖИТ БУС ЗААВАРЧИЛГАА**

№	Агуулга	Зааварчилгаа авсан ажилтны тоо
1	УБЦТС ТӨХК-д гарсан осол	131
2	“Ухаа худаг” ЦС-д гарсан галын зөрчил	128
3	Галын аюулгүй байдлын зааварчилгаа	91
4	“Увс цахилгаан түгээх сүлжээ ХХК”-ийн монтер Б нь ажил гүйцэтгэх үедээ цахилгаан гүйдэлд нэрвэгдсэн осол	49
5	ЭДЦС ТӨХК –ийн зуухны шаар цэвэрлэгч Э- нь зуухны шлак цохих трубанд цохиулж гэмтсэн осол	
6	УБЦТС ТӨХК Ашиглалт засварын “Зүүн төв” –ийн шуурхай үйлчилгээний хэсгийн туслах монтер Э нь ажил гүйцэтгэхдээ хүчдэлд цохиулж гэмтсэн осол	
Нийт		399

**ХАБЭА-н нийт үзлэгийг тоон мэдээллээр харуулбал:**

Ажлын байрны үзлэг, шалгалт	Үзлэгийн тоо (давхардсан тоогоор)	Илэрсэн зөрчил (давхардсан тоогоор)	Арилгасан зөрчил (давхардсан тоогоор)	Гүйцэтгэл
Анхан шатны үзлэг (өдөр бүр)	1236	491	489	99%
II шатны үзлэг (сард 1-ээс доошгүй удаа)	83	111	111	100%
III шатны үзлэг (Улиралд 1-ээс доошгүй удаа)	5	55	51	92.2%
Нийт	1324	657	651	

**ХАБЭА-н III шатны үзлэгийг тоон мэдээллээр харуулбал**

Үзлэгийн давтамж	Илэрсэн зөрчлийн тоо	Гүйцэтгэл	Үзлэгийн сэдэв
I Улирал	29	100%	Цехийн хэмжээнд ажлын байрны эрсдлийг үнэлэн үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч хэрэгжүүлэн эрсдлийн түвшинг бууруулах заавар зөвлөмж өгөх.
II Улирал	7	95%	Станцын хэмжээнд ХАБЭА дүрэм, журмын мөрдөлт, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эрсдлийн түвшинг бууруулж, заавар зөвлөмж өгөх.
IV улирал	15	97%	Ажлын байрны эрсдлийг үнэлэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

**3-р шатны үзлэгийг ангилан харуулбал:**

№	Цех, хэсэг	Наряд	Зааварчилгаа	Ажлын байрны эмх цэгц	ГАБ	Гэрэлтүүлэг	Тоосжилт	Журнал хөтлөлт
1	Зуухан цех	2	4	12	1	1	2	1
2	ТДЦех	1	2	10	1	1	2	1
3	Авто хэсэг		2	3				1
4	Хими хэсэг		1					
5	Цахилгааны хэсэг		1	3	1			
6	ДХХА хэсэг							
Нийт		3	10	30	3	2	4	3

**3.4. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЛЭГ:**

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн цех, хэсгүүдийн галын хор, багаж хэрэгсэл, сарай, галын усны гадна, дотор гидранит, галын дохиолуудад хийсэн үзлэг шалгалтыг сар бүр хяналт тавьж ажиллаж байна.

№	Авах арга хэмжээ	Дүрэм журам, стандартын заалт	Гүйцэтгэл
1	Галын анхан шатны багаж хэрэгслийг шалгах албан тушаалтанг томилох	MNS 5566:2005 стандартын 5.14 дэх заалт /Байгууллага, аж ахуйн нэгж бүр гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, бэлэн байдал хариуцсан албан тушаалтныг томилж анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийг хяналтын карттай болгож хагас жилд нэг удаа үзлэг хийж чанар байдлын талаар тэмдэглэгээ хийнэ./	100%
2	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн ахуйн хэрэгцээнд хэрэглэхгүй байх.	ГАБҮД-н 8.59 дэх заалт / Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг гал унтраах үлй ажиллагаанаас бусад зүйлд ашиглахыг хориглоно/	100%

3	Дутуу байгаа галын хорнуудыг гүйцээж, хяналтын карттай болгож сар бүр тогтмол үзлэг хийж баталгаажуулах	MNS 5566:2005 стандартын 6-дэх заалт ГАБҮД-н 8.3 дэх заалт / Аж ахуйн нэгж, байгууллага бүр өөрийн барилга байгууламж, объект бүрийг шаардлагатай тоо хэмжээний, бүрэн ажиллагаатай гал унтраагуураар хангана. Барилга байгууламжид байрлуулах гал унтраагуурын тоо, төрлийг тухайн барилга байгууламжийн талбайн хэмжээ, галын ангилал, гал унтраагуурын унтраах хүчин чадал зэргийг харгалзан энэ дүрмийн 1, 2 дугаар хавсралтад заасан үзүүлэлтэд нийцүүлэн сонгоно./	100%
4	Галын сарааны дутуу байгаа багажыг гүйцээж, галын сараанд байх багажнуудыг жагсаалтыг гарган батлуулж тавих	ГАБҮД-н 4-р хавсралтын дагуу	100%
5	Оффисын галын гидрантуудыг үзэж шалган протокол хөтлөх	ГАБҮД-н 8.19 буюу / Гал унтраах усан хангамжийн сүлжээний ажиллагааг жилд хоёроос доошгүй удаа (хавар, намар) шалгаж, уг үйл ажиллагааг баримтжуулна./	100%
6	Галын усны гадна гидрантын бэлэн байдлыг хангаж үзлэг хийж баримтжуулах	ГАБҮД-н 8.25 дэх заалт /Барилгын гадна галын гидрантыг байнга бэлэн байдалд байлгаж, өвөл хөлдөхөөс хамгаалан дулаалж цэвэрлэсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн талбайн 50 м доторх гадна галын гидрантын бүрэн бүтэн байдалд хяналт тавина./	100%
7	Гал унтраах автомат систем, дохиолол, дуут дохио, утаа зайлуулагч зэргийг урьдчилан сэргийлэх үзлэгийн хуваарь гаргаж батлуулан тогтмол үзлэг хийж, баримтжуулах	ГАБҮД-н 8.48 буюу /Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан үед мэдээлэх дуут болон гэрлэн дохио, аврах зам, гарцын гэрлэн дохио, хаалга, зам гарц, аврах үйл ажиллагааны техник хэрэгслийг техникийн үндсэн бичиг баримтад тусгасан засвар үйлчилгээний хугацаа, үзлэгийн хуваарь, гэрээ, зөвшөөрлийн бичигт заасан хугацаанд техникийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж, энэ талаар тэмдэглэл хөтөлнө./	100%
8	Гал унтраах автомат систем, дохиолол, дуут дохио, утаа зайлуулагч зэрэгт тогмол үйлчилгээ хийж баримтжуулах	ГАБҮД-н 8.49 заалт / Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан тохиолдолд мэдээлэх дуут болон гэрлэн дохиог улирал тутам шалгаж, зохих техникийн үйлчилгээг хийнэ/	100%
9	Галын усны гидрантуудын бүрэн бүтэн байдлыг хангаж, ус нээх, хаах хаалтыг зөв байрлалд оруулж засварлан, хагас жил тутам /хавар, намар/ үзлэг шалгалт хийж протокол хөтлөн баримтжуулах.	ГАБҮД-н 8.27 дэх заалт / Барилгын доторх галын гидрант (галын кран) нь байнгын даралттай, стандартад нийцсэн хайрцаг сав, хоолой, хушуутай байна. Хоолой нь усны шугам, галын хушуунд холбоотой байх бөгөөд эвхэлтийг жилд 1-ээс доошгүй удаа солино. Галын усны шугам, хоолойны холбох хэрэгсэл нь гал унтраах ангийн автомашин, багаж хэрэгслийг залган ажиллуулахад саадгүй байх шаардлагатай../	100%
10	Галын дохиоллын системийг ажилд бүрэн оруулж,	ГАБҮД-н 8.49 заалт / Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан тохиолдолд	100%

	ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллах	мэдээлэх дуут болон гэрлэн дохиог улирал тутам шалгаж, зохих техникийн үйлчилгээг хийнэ/	
11	Яндангийн аянга зайлуулагч, Дизель түлшний АА-н газардуулгын хэмжилтийг хийлгэж хэвших	ГАБҮД-н 4.4 дэх заалт /Аянгын хүчтэй үйлчлэлийн бүсэд байрласан барилга байгууламж нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан аянгаас хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон байна./	100%
12	Ажлын байр талбайг шатамхай шингэнээр цэвэрлэхгүй байх	ГАБҮД-н 2.35.11 заалт /Өрөө тасалгаа, хувцас хэрэгслийг бензин, түлш зэрэг шатах бодис, материалаар цэвэрлэх, угаах, хөлдсөн шугам хоолойг ил гал, бамбар, гал үлээгчээр гэсгээхийг хориглоно (зөвхөн халуун ус, элс уураар гэсгээнэ) заалт зөрчигдсөн	100%
13	Галын хүрз, царил, жоотуу, дэгээ, цохиур гэх мэт гал унтраах зарим багаж хэргэслүүдийг ашиглагдах нөхцөл байдалд нь тулгуурлан ишийг нь 3м-ээс багагүй урт болгох		100%
14	Цахилгааны ХХБ-ууд, Ажилчдын авто граш, Спорт болон хурлын заал, агуулахуудад гал унтраах үед ашиглах элстэй хайрцаг байршуулах.		100%
18	Агуулахад галын хор болон бусад багаж хэрэгсэлүүд байхгүй бол 2024 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгах		100%
19	Гал унтраах элсийг орлуулж оронд зуухнаас шигшигдсэн нарийн шааргыг ашиглах		100%

### 3.5. ТЕХНИК ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Техник-технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажил зохион багуулсаны үр дүнд 2023 онд аварь, осол, саатал, гал түймэр гараагүй болно.

2023 онд төлөвлөгөөт бус 3 зогсолт гаргасан. Үүнд:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөрчлийн тоо
1	Төлөвлөгөөт бус зогсолт	Тоо	3
2	Хангагчийн буруутай үйл ажиллагаа	Тоо	0
3	Үүнээс Аварь	Тоо	0
	1-р зэргийн саатал	Тоо	0
	2-р зэргийн саатал	Тоо	0
	Үйлдвэрлэлийн осол	Тоо	0
	Гал	Тоо	0
4	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруугаас	Тоо	0
5	Хэрэглэгчийн буруугаас	Тоо	0
6	Бусад шалтгаанаар	Тоо	0

**А. Зуух №1:** 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр зуух №1-ийн галын хотлын баруун хойд хананы буланд 12 метрийн өндөртэй шат засаж үзлэг хийхэд баруун хананы 1-р экран хоолой цооролт үүссэнээр төлөвлөгөөт бус зогсолт хийсэн.

**Дүгнэлт :**

1. 2021 оны 11 сарын 20 өдөр гарсан гэмтлийг засварлах явцад оруулга хийсэн экран хоолойнуудыг полосатай нийлүүлж гагнах үед гагнуур товойлгож гагнасны улмаас тухайн хэсэгт хуйлралтын хэмжээ ихсэж цооролт үүсэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

2. Үнслэг ихтэй, фракц том /10мм-ээс дээш/ нүүрс хэрэглэсний улмаас ашиглалтын явцад тухайн экраныг түргэн элэгдүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

**Б. Зуух №2:** 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зуух №2-ын Б циклоноос галын хотол руу дутуу шатсан материал буцаах хоолойн амсар орчмын шавар элэгдэж 2 хоолой цоорсон. Мөн галын хотлоос Б циклоны эргэлтийн хэсгийн хананы шавар элэгдэж 10 ширхэг хоолой ил гарсан ба 1 хоолойд цооролт үүссэнээр төлөвлөгөөт бус зогсолт хийсэн.

**Дүгнэлт:** Зууханд түлж байгаа нүүрсний бүхэллэг нь зуухны ашиглалтын зааврын 3.1-д заасны дагуу 0-10мм хэмжээтэй нүүрс түлэх шаардлагатай бөгөөд уг заалтыг зөрчиж 10мм-ээс дээш хэмжээтэй нүүрсээр зуухыг тэжээсний улмаас галын хотолд шаталт явагдах үед эргэлдэн буцлах эргэлтийн тоо болон буцалж байгаа нэгж нүүрсний хүндийн жин нэмэгдэж, галын хотол болон циклоны шаврыг эрчимтэй элэгдүүлж хоолойнууд ил гарч, гадна талаасаа механик элэгдэлд орж цооролт үүссэн байна.

**В. Зуух №3:** 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр А циклоны шалны 27-р хоолойн маталттай хоолойн доод хэсэгт цооролт үүссэнээр зуух №3-ыг төлөвлөгөөт бус зогсолт хийсэн.

**Дүгнэлт:** Зууханд түлж байгаа нүүрсний бүхэллэг нь зуухны ашиглалтын зааврын 3.1-д заасны дагуу 0-10мм хэмжээтэй нүүрс түлэх шаардлагатай бөгөөд уг заалтыг зөрчиж 10мм-ээс дээш хэмжээтэй нүүрсээр зуухыг тэжээсний улмаас галын хотолд шаталт явагдах үед эргэлдэн буцлах эргэлтийн тоо болон буцалж байгаа нэгж нүүрсний хүндийн жин нэмэгдэж, галын хотол болон циклоны шаврыг эрчимтэй элэгдүүлж хоолойнууд ил гарч, гадна талаасаа механик элэгдэлд орж цооролт үүссэн байна.

Төлөвлөгөөт бус 3 зогсолтоор цаашид авах арга хэмжээг авч ажилласнаар дахин төлөвлөгөөт бус, авари, саатал гараагүй.

**3.6. ГЭМТЛИЙН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

№	Авах арга хэмжээ	Хариуцах ажилтан	Гүйцэтгэл
1	Засварын ажлын явцад гүйцэтгэлийн болон хяналтын чанарыг сайжруулах.	Цех хэлтсүүд	2023 оны их болон урсгал засварын ажлуудад хяналтыг тогтмол тавьж ажилласан.
2	Зууханд төслийн нүүрснээс бусад нүүрс түлэхэд халах гадаргууд хүндрэл үүсч байгаа тул аль болохоор төслийн бус нүүрснээс татгалзах.	Зуухан цехийн дарга	2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр ЭХЯ, “Амгалан ДС” ТӨХК, “Монкоул Петро Майнинг” ХХК-ын хамтарсан бүрэлдэхүүн Цайдам уурхайн нүүрсний шинж чанар, ачилт буулгалтын талбай, олборолтын мөргөцөг зэрэг газруудад үзлэг шалгалт зохион байгуулсан. Тухайн үзлэг шалгалтаар “Монкоул Петро Майнинг” ХХК-ийн нийлүүлж буй нүүрс нь Амгалан ДС-ын зууханд таарахгүй болох нь

			тогтоогдож гэрээг цуцалсан. Мөн бусад уурхай болох Багануур, Шивээ-Овоо, Бөөрөлжүүт, Алагтолгойн нүүрснүүдийг зуух руу татхаас өмнө буюу вагон дээрээс дээж аван шинжилгээ хийсний үндсэн дээрээс зуух руу татах болон буцаах арга хэмжээ аван ажиллаж байна.
3	Нүүрсний ширхэгжилт зуухны халах гадаргуунуудад хэрхэн нөлөөлөх талаар судлах.	Зуухан цехийн дарга	Үйлдвэрлэгч байгууллагтай холбогдож эргэлдэх буцламтгай шаталтат зууханд нүүрсийг шатаах үед нүүрсний ширхэгжилтээс шууд хамаарч халах гадаргуун элэгдэл явагддаг тул нүүрсний шинж чанар, бүхэллэгт анхаарах талаар мэдэгдсэн. Зуухны өргөтгөлтэй холбоотойгоор анхдагч бутлуур суурилуулж нүүрсний ширхэгжилтийг багасгаж зууханд түлж байна.
4	Гэрээнд заагдсан нүүрсний шинж чанар хангаагүй нийлүүлэгч компанид албан бичгээр шаардлага хүргүүлж, нүүрсийг буцааж хэвших.	Инженерийн хэсэг	Гэрээнд заагдсан нүүрсний шинж чанар хангаагүй нийлүүлэгч компанид албан бичгээр шаардлага хүргүүлж, нүүрсийг буцааж хүлээн авахгүй талаар мэдэгдэж ажиллаж байна.
5	Зууханд хэрэглэсэн нүүрс нь галын хотол болон циклоны шаврыг түргэн элэгдүүлж байгаа тул Зуух №2-ыг ойрын хугацаанд зогсоож үзлэг хийх.	Зуухан цехийн дарга	Өвлийн оргил ачаалал үеэр зуух №2-ыг зогсоох боломжгүй гэж ДҮТ ТӨХХК, УБДС ТӨХК нар мэдэгдэж зуухыг зогсоох боломжгүй болсон.
6	Зуух тус бүрийн экран хоолойд оруулга хийх үедээ цонхолж гагнасан хоолойнуудыг бүрэн солих.	Зуухан цехийн дарга	2023 оны их болон урсгал засварын хугацаанд зуух тус бүрийн галын хотолд цонхолж гагнасан экран хоолойнуудыг 3 метрээс доошгүй урттайгаар оруулга оруулсан.
7	Зуухны өргөтгөлтэй холбогдуулан гүйцэтгэгч компанитай зөвшилцөн 2023-2024 оны өвлийн их ачааллаас өмнө анхдагч бутлуурыг суурилуулах болон үндсэн бутлуурын сегментүүдийг солих.	Ерөнхий инженер, Төслийн ахлах инженер, ТДЦехийн дарга	Зуухны өргөтгөлтэй холбогдуулан гүйцэтгэгч компанитай зөвшилцөн 2023-2024 оны өвлийн их ачааллаас өмнө анхдагч бутлуурыг суурилуулах болон үндсэн бутлуурын сегментүүдийг сольж ашиглалтад оруулсан.
8	Гэрээнд заагдсан нүүрсний шинж чанар хангаагүй нийлүүлэгч компанид албан бичгээр шаардлага хүргүүлж, гэрээний дагуу шаардлага хангасан нүүрсээр хангуулах ажлыг зохион байгуулах.	Инженерийн хэсгийн ахлах инженер	Нүүрс нийлүүлэгч уурхай компаниудад албан бичгээр шаардлага хүргүүлж, гэрээний дагуу шаардлага хангасан нүүрсээр хангах талаар мэдэгдэж шинж чанар хангаагүй нүүрсийг буцааж ажиллав.
9	2023-2024 оны халаалтын улиралд үндсэн тоноглолын ажиллагааны графикайг УБДС ТӨХК-тай хамтарч зөвшилцөн, ДҮТ ТӨХХК-	Инженерийн хэсгийн ахлах инженер	2023 оны 09 дүгээр сард "ДҮТ" ТӨХХК болон "УБДС" ТӨХК-ийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран Амгалан Дулааны станцын 2023-2024 оны халаалтын улирлын горим ажиллагаа болон үндсэн тоноглолын

	иар батлуулан мөрдөж ажиллах.		явалт зогсолтын графикийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна.
10	Зуух тус бүрийн экран хоолойнуудыг цонхолж, наплавка хийж гагнасан хоолойнуудыг зуны засварын хугацаанд бүрэн солих.	Зуухан цехийн дарга	2023 оны их болон урсгал засварын хугацаанд зуух тус бүрийн галын хотолд цонхолж гагнасан экран хоолойнуудыг 3 метрээс доошгүй урттайгаар оруулга оруулсан.
11	Зуух №3-ыг 2022-2023 оны үндсэн тоноглолын ажиллагааны графикийн дагуу зогсоож, үзлэг үйлчилгээ хийх. /2023 оны 02 дугаар сард/	Зуухан цехийн дарга	Өвлийн оргил ачаалал үеэр зуух №3-ыг зогсоох боломжгүй гэж ДҮТ ТӨХХК, УБДС ТӨХК нар мэдэгдэж зуухыг зогсоох боломжгүй болсон.
12	Зуухнуудад горимын туршилт хийж, горимын картыг шинэчлэх.	Хяналтын хэлтэс, Инженерийн хэсэг	“Термокалори” ХХК-тай хамтарч Зуухнуудад горимын туршилт хийх, горимын картыг шинэчилж, горимын картыг мөрдүүлж ажиллаж байна.
13	Зуухнуудын “Б” циклоны эргэлтийн хэсэг, циклоны буух хоолойн амсрын шавар илүү элэгдэж байгаа шалтгааныг тодорхойлох.	Зуухан цехийн дарга Хяналтын хэлтэс, Инженерийн хэсэг	Зуухны горимын туршилт хийх явцад хоёрдогч агаарын 1 ширхэг хаалт гацаатай байсанг тодорхойлсон. Хоёрдогч агаар өгөлт жигд бус болсноор Зуухнуудын Б талд элэгдэх шалтгаан болсон байх магадлалтай байна.
14	А, Б циклоны таазны экран хоолойнуудын элэгдэж байгаа хэсгийг элэгдэлээс хамгаалж бүтэн шавардлага хийх талаар судлаж хэрэгжүүлэх / 2023 оны засвараар/	Зуухан цехийн дарга Хяналтын хэлтэс	Зуухны өргөтгөлтэй холбогдуулан гүйцэтгэгч компани болох “Хунан индастриал экүйпмент инсталэйшн” ХХК-тай холбогдож А, Б циклоны таазны экран хоолойн элэгдлийн талаар судлаж, элэгдлээс хамгаалсан шавардлагыг 2023 оны засварын ажлын хугацаанд зуух тус бүрт хийж гүйцэтгэсэн.

### 3.7. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 116 МВт-ЫН НЭГ ЗУУХААР ӨРГӨТГӨХ ТӨСЛИЙН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа 50”-д тусгагдсаны дагуу ЭХСайдын зөвлөлийн 2021 оны 12-р сарын 10-ны өдрийн хурлаас Амгалан дулааны станцыг 116 МВт-ийн 1 зуухаар өргөтгөхийг зөвлөсний дагуу ТЭЗҮ-ийг боловсруулж ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн. Амгалан дулааны станц ТӨХК-ийг өргөтгөснөөр суурилагдсан хүчин чадал 400 Гкал буюу 464 МВт болно.

Амгалан дулааны станцыг QXF 116-1.6/130/70-L маркийн нэг зуухаар өргөтгөх төслийг БНХАУ-ын “Хунан индастриал экүйпмент инсталэйшн” ХХК 65,6 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр шалгарсан.

Амгалан дулааны станцыг 116 МВт-ын нэг зуухаар өргөтгөх төслийг хэрэгжүүлснээр:

№	Төслийн мэдээлэл	Арга хэмжээ
1	Хэрэгжүүлэгч байгууллагын нэр	Хунан Индустриал Экүйпмент Инсталэйшн ХХК
2	Төслийн нэр	Амгалан дулааны станцыг 116 МВт-ын хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төсөл
3	Эхлэх хугацаа (огноо)	2023 оны 04-р сарын 01
4	Дуусах хугацаа (огноо)	2024 оны 08-р сарын 01
5	Санхүүжилтийн эх үүсвэр	Монгол улсын хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм Лизинг ХХК, Амгалан дулааны станц ТӨХК
6	Санхүүжилтийн төрөл	Зээл болон өөрийн санхүүжилт
7	Санхүүжилтийн хэмжээ, валютын төрөл	65,689,769,899 /Жаран таван тэрбум зургаан зуун наян есөн сая долоон зуун жаран есөн мянга найман зуун ерэн ес/, төгрөг
8	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зорилго	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн хэрэглэгчдийн дулааны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах болон бусад эх үүсвэрийг өргөтгөх нөхцлийг бүрдүүлэх
9	Хамрах хүрээ	“Амгалан дулааны станц”ТӨХК-ийн одоо ажиллаж байгаа 300Гкал/ц (348 МВт)-ын хүчин чадалтай дулааны станцын барилгын урд талбайд залгуулан дулааны нэгж хүчин чадал 100Гкал/ц (116 МВт)-ын хүчин чадалтай ус халаагуурын нэг зуухаар өргөтгөнө.
10	Хүлээгдэж байгаа үр дүн	1. Амгалан дулааны станцын суурилагдсан хүчин чадал 400 Гкал буюу 464 МВт болно. 2. Амгалан дулааны станц нь жилд 1.250.000 Гкал/ц дулааны эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай болно. 3. Төслийн 65.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 5 жилд нөхнө. 4. Улаанбаатар хотын зүүн хэсгийн дулаан хангамж сайжирч, Баянзүрх дүүрэг, Улиастай орчмын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болох 96,000 айл өрхийн орон сууцны шинэ хорооллуудыг дулаанаар хангагдана
11	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийн тайлан	Зуух болон туслах тоноглолуудын угсралт, суурилуулалтын ажил бүрэн дууссан. Туслах тоноглолуудын туршилт тохируулгын ажил бүрэн дууссан. Зуухны туршилт тохируулгын ажил үргэлжилж байна. Төслийн хүрээнд шинээр баригдаж буй 28000 м.куб багтаамжтай үнсний силос, вагон гэсгээгчийн байгууламж, нүүрсний агуулах зэрэг байгууламжуудын барилга угсралтын ажил болон тоног төхөөрмж угсралтын ажлуудыг цаг агаарын нөхцөл сайжрах үед хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. <b>Төслийн нийт гүйцэтгэл: 95%</b>

Амгалан дулааны станцыг өргөтгөх QXF 116-1.6/130/70-L маркийн нэг зуухны үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт
1	Дулааны чадал	МВт	116
2	Сүлжээний усны зарцуулалт	Тн/цаг	1651
3	Сүлжээний усны даралт	МПа	1.6
4	Сүлжээний буцах усны температур	°С	70
5	Зуухнаас гарах сүлжээний усны температур	°С	130
6	Галын хотлын буцлах давхаргын дундаж температур	°С	890
7	Нүүрсний зарцуулалт	Тн/цаг	30.33
8	Гарах утааны температур	°С	135
9	Зуухны АҮК	%	90.93

Төслийн хүрээнд хийгдэж байгаа томоохон ажлууд дурдья. Үүнд:

1. 116 МВт-ын хүчин чадалтай иж бүрэн нэг зуух угсрагдсан.
2. 10000 м<sup>3</sup>, /88x32\*9,7м3/ багтаамжтай нүүрсний агуулах баригдсан.
3. 8 вагон багтах багтаамжтай вагон гэсгээгч барилга баригдсан.
4. 7000 метр куб х 4 ш, 28000 метр куб багтаамжтай үнсний силос баригдсан.
5. Технологийн ус цэвэрлэгээний өргөтгөл баригдсан.
6. 2РСМ700х1500 хүчин чадалтай нүүрс бутлагч суурилагдсан.

Үнсний силос



4-р зуухны барилга



Вагон гэсгээгч



Нүүрсний агуулах



**ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

**4.1.ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ**

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	841.8	1,034.0	1,037.3	3.2	0.3
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	14.0	14.5	13.0	-1.4	-10.0
	<b>Дулаан түгээлт</b>	мян.Гкал	<b>827.8</b>	<b>1,019.5750</b>	<b>1,024.2400</b>	<b>4.6650</b>	0.5
	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>24,219,889.5</b>	<b>67,734,959.2</b>	<b>67,837,919.0</b>	<b>102,959.8</b>	<b>0.2</b>
2	Үүнээс Үйл ажиллагааны орлого	мян.төг	24,058,669.4	67,543,994.1	67,653,283.5	109,289.3	0.2
	Үйл ажиллагааны бус орлог	мян.төг	161,220.1	190,965.1	184,635.6	-6,329.5	-3.3
3	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>32,779,116.4</b>	<b>48,582,049.3</b>	<b>45,449,266.3</b>	<b>-3,132,783.0</b>	<b>-6.4</b>
	Үүнээс Удирдлагын зардал	мян.төг	138,166.8	95,993.6	87,345.8	-8,647.8	-9.0
4	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	мян.төг	<b>-8,559,226.9</b>	<b>19,152,909.9</b>	<b>22,388,652.7</b>	<b>3,235,742.8</b>	<b>16.9</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	мян.төг	<b>-8,802,518.5</b>	<b>18,371,253.6</b>	<b>20,627,266.8</b>	<b>2,256,013.2</b>	<b>12.3</b>
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
7	Нийт ажиллагсадын тоо	хүн	186.0	192.0	192.0	0.0	<b>0.0</b>
8	Нийт цалингийн сан	сая.төг	4,442.0	5,614.6	5,584.6	-30.0	-0.5
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,990,163.5	2,436,878.0	2,423,871.5	-13,006.5	-0.5
10	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	39,596.1	47,649.3	44,373.6	-3,275.7	-6.9
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төгрөг					
12	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.35	0.72	0.67	-0.05	-6.59
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	1,228.6	2,683.8	2,522.6	-161.2	-6.0
14	<b>Нийт авлага</b>	<b>сая.төг</b>	<b>895.9</b>	<b>800.0</b>	<b>5,488.3</b>	<b>4,688.3</b>	<b>586.0</b>
	Үүнээс Найдваргүй	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	
15	<b>Нийт өглөг</b>	<b>сая.төг</b>	<b>9,544.4</b>	<b>49,098.6</b>	<b>49,522.2</b>	<b>423.6</b>	<b>0.9</b>
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	6,736.4	23,535.6	17,237.4	-6,298.2	-26.8
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	2,808.0	25,563.0	32,284.8	6,721.8	26.3
16	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/Гкал	170.6	162.8	164.9	2.1	1.3

## 4.2.НИЙТ ОРЛОГО

Нийт 67,653.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 184.6 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлоготой ажиллаж, төлөвлөгөөт орлогыг 103.0 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар нэмэгдүүлсэн. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 109.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төлөвлөснөөс 4.7 мянган Гкал дулааны эрчим хүч илүү түгээсэнтэй холбоотой.



**Борлуулалтын орлогын дэлгэрэнгүй тайлан**

/сая төгрөгөөр/

Сар	ДЭХ-ний түгээлт		Үйл ажиллагааны чадлын орлого	Төслийн чадлын тариф	Нийт дүн
	УБДС ТӨХК	МОХН УБТЗ нийгэмлэг			
1 сар	4,862.1	8.3	808.0	-	5,678.5
2 сар	3,697.5	5.6	808.0	-	4,511.1
3 сар	3,315.2	4.2	808.0	-	4,127.5
4 сар	2,424.6	3.3	808.0	3,549.9	6,785.8
5 сар	406.6	-	808.0	3,549.9	4,764.5
6 сар	-	-	808.0	3,549.9	4,357.9
7 сар	-	-	808.0	3,549.9	4,357.9
8 сар	-	-	808.0	3,549.9	4,357.9
9 сар	453.8	-	808.0	3,549.9	4,811.7
10 сар	2,063.1	4.6	808.0	3,549.9	6,425.7
11 сар	3,707.2	5.6	808.0	3,549.9	8,070.7
12 сар	5,038.7	7.4	808.0	3,549.9	9,404.0
<b>Дүн</b>	<b>25,968.9</b>	<b>39.1</b>	<b>9,696.2</b>	<b>31,949.1</b>	<b>67,653.3</b>
<b>хувь</b>	<b>38.4</b>	<b>0.1</b>	<b>14.3</b>	<b>47.2</b>	<b>100.0</b>

Үйл ажиллагааны бус орлого-д цайны газрын түрээсийн орлого, үнс борлуулсаны орлого, цахим тендерийн хураамж, алданги, улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн

хөрөнгө оруулалтын ажлын тухайн онд ногдох орлогын дүн зэрэг багтсан. Үнсний борлуулалт 25.5 сая төгрөгөөр буурсанаас үйл ажиллагааны бус орлого 3.3 хувиар буурсан байна.

**Үйл ажиллагааны бус орлогын дэлгэрэнгүй тайлан**

/сая төгрөгөөр/

Сар	Үнсний борлуулалт	Цайны газрын түрээс	Хойшлогдсон орлого	Заалны түрээс	Цахим тендерийн хураамж	Алданги	Хүүний орлого	Бусад орлого	Нийт дүн
1 сар	2.1	0.3	8.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	10.7
2 сар	15.3	0.3	8.3	0.4	0.0	0.0	0.0	5.6	29.9
3 сар	6.4	0.3	8.3	0.1	0.2	0.0	0.0	0.0	15.3
4 сар	2.8	0.3	8.3	0.1	0.0	0.0	0.1	0.0	11.6
5 сар	0.0	0.3	8.3	0.7	0.0	0.0	0.4	0.6	10.3
6 сар	0.0	0.3	8.3	0.0	0.0	0.0	0.0	8.9	17.6
7 сар	0.0	0.3	8.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	8.6
8 сар	0.0	0.3	8.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	8.6
9 сар	5.8	0.3	8.4	0.1	0.0	2.9	0.1	0.0	17.7
10 сар	7.7	0.3	7.9	0.0	2.7	6.1	0.0	0.0	24.8
11 сар	3.5	0.3	7.9	0.0	0.0	1.2	0.0	0.0	12.9
12 сар	0.0	0.3	7.5	0.0	0.2	0.1	0.0	8.3	16.5
<b>Дүн</b>	<b>43.6</b>	<b>4.0</b>	<b>98.3</b>	<b>1.3</b>	<b>3.1</b>	<b>10.3</b>	<b>0.7</b>	<b>23.4</b>	<b>184.6</b>
<b>Хувь</b>	<b>23.6</b>	<b>2.1</b>	<b>53.2</b>	<b>0.7</b>	<b>1.7</b>	<b>5.6</b>	<b>0.4</b>	<b>12.7</b>	<b>100.0</b>

**4.3.НИЙТ ЗАРДАЛ**

**НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

№	Зардлын төрлүүд	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	%
1	Түлшний зардал	12,676,839.4	19,606,237.2	19,958,684.2	352,447.0	1.8
2	Туслах материалын зардал	110,717.6	211,136.4	121,624.0	-89,512.3	-42.4
3	Шатахууны зардал	223,674.7	362,044.5	322,016.2	-40,028.4	-11.1
4	Сэлбэг хэрэгсэл, материал хангамж	834,664.7	1,606,230.1	1,377,980.8	-228,249.3	-14.2
5	Урсгал засвар	328,480.1	467,795.0	426,849.1	-40,945.9	-8.8
6	Үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал	4,331,718.6	5,532,825.9	5,510,572.1	-22,253.8	-0.4
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	654,749.0	847,441.6	843,977.8	-3,463.8	-0.4
8	Ашиглалтын зардал /Цахилгаан/	5,499,263.5	8,553,493.7	8,383,090.8	-170,402.9	-2.0
9	Ашиглалтын зардал - Ус	54,502.5	121,796.7	98,033.1	-23,763.6	-19.5
10	Албан томилолтын зардал	1,911.9	2,043.8	2,119.6	75.8	3.7
11	Хангамжийн зардал	50,349.6	50,568.3	49,788.5	-779.8	-1.5
12	Хэвлэл захиалга	2,147.3	2,472.0	2,472.0	0.0	0.0
13	Харилцаа холбооны зардал	10,140.3	13,372.2	11,116.6	-2,255.6	-16.9
14	Харуул хамгаалалтын зардал	62,836.4	75,403.6	75,403.6	0.0	0.0
15	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал	192,795.4	322,804.5	221,671.8	-101,132.7	-31.3
16	Даатгалын зардал	8,607.7	8,509.6	8,347.8	-161.7	-1.9
17	Байгаль орчин хамгаалах зардал	20,645.2	24,554.5	20,909.1	-3,645.5	-14.8
18	Галын аюулаас хамгаалах зардал	40,386.5	21,520.0	3,990.9	-17,529.2	-81.5
19	Гүйцэтгэх удирдлагын зардал	138,166.8	95,993.6	87,345.8	-8,647.8	-9.0
20	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	75,159.6	111,276.5	108,186.7	-3,089.8	-2.8
21	Зохицуулалт үйлчилгээний хөлс	58,500.0	79,200.0	79,200.0	0.0	0.0
22	Гадны үйлчилгээний хөлс	183,626.5	460,103.7	341,538.8	-118,564.8	-25.8
23	Түрээсийн зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0
24	Сургалтын зардал	45,829.9	53,950.0	51,511.9	-2,438.1	-4.5
25	Найдваргүй авлагын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0
26	Үйл ажиллагааны бусад зардал	14,823.1	0.0	10,323.9	10,323.9	0.0
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>25,620,536.1</b>	<b>38,630,773.4</b>	<b>38,116,755.1</b>	<b>-514,018.3</b>	<b>-1.3</b>
27	Элэгдлийн зардлын дүн	6,603,765.1	6,615,403.1	6,624,529.0	9,125.9	0.1
28	Үл хөдлөх хөрөнгийн татвар	140,064.1	171,692.1	168,429.2	-3,262.9	-1.9
29	АТӨЯХ-н албан татвар	1,172.3	1,328.8	1,025.4	-303.4	-22.8
30	Газрын төлбөр	12,610.8	12,739.8	12,610.8	-129.0	-1.0
31	Бусад татвар	10,394.3	15,431.5	6,637.1	-8,794.5	-57.0
<b>Орлогын албан татвараас бусад татвар</b>		<b>164,241.5</b>	<b>201,192.2</b>	<b>188,702.5</b>	<b>-12,489.7</b>	<b>-6.2</b>
<b>Бүрэн өөрийн өртөг</b>		<b>32,388,542.7</b>	<b>45,447,368.7</b>	<b>44,929,986.6</b>	<b>-517,382.1</b>	<b>-1.1</b>
32	Урт хугацаат зээлийн хүүгийн зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0
33	Ажилчдын нийгмийн зардал	390,573.7	586,262.8	519,279.7	-66,983.1	-11.4
<b>ХОӨ-өөр нөхөгдөх зардал</b>		<b>32,779,116.4</b>	<b>46,033,631.5</b>	<b>45,449,266.3</b>	<b>-584,365.2</b>	<b>-1.3</b>
34	Санхүүгийн түрээсийн хүүний зардал	0.0	2,548,417.9	0.0	-2,548,417.9	0.0
<b>Үйл ажиллагааны бус бусад зардал</b>		<b>0.0</b>	<b>2,548,417.9</b>	<b>0.0</b>	<b>-2,548,417.9</b>	<b>0.0</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>32,779,116.4</b>	<b>48,582,049.3</b>	<b>45,449,266.3</b>	<b>-3,132,783.0</b>	<b>-6.4</b>

Батлагдсан төлөвлөгөөнөөс нийт зардлыг 3,132.8 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар бууруулж, 45,449.3 сая төгрөгийн зардалтай ажилласан. Үүнд:


**Түлшний зардал:**

- Дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөө 4.7 мянган Гкал нэмэгдэж, 3,613 тн нүүрс илүү зарцуулсанаар 185.2 сая төгрөг,
- Зуухны ашигт үйлийн коэффициент төлөвлөснөөс 0.8% буурч, 627 тн нүүрс илүү зарцуулсанаар 3.1 сая төгрөг,
- Шивээ овоо ХК-аас төлөвлөснөөс 15,065 тн нүүрс дутуу, Цэцэнс майнинг энд энерги ХХК-аас 18,062 тн нүүрс илүү зарцуулсанаар үнийн зөрүүгээс шалтгаалан 1 тн тутамд 5,090 төгрөг буюу нийт 80.0 сая төгрөг,

- Нийт 3,000 тн нүүрс төлөвлөснөөс илүү татан авсанаар тээврийн зардалд 1 тн тутамд 4,580 төгрөг буюу нийт 13.7 сая төгрөг,
- Алаг толгойн уурхайгаас 616.8 тн чулуун нүүрс төлөвлөснөөс илүү зарцуулснаар 37.4 сая төгрөг,
- Зуухны галлагааны дизель түлш төлөвлөснөөс 0.5 тн илүү зарцуулсанаар 4.1 сая төгрөг тус тус нэмэгдэж, нийт 352.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


**Санхүүгийн түрээсийн хүүний зардал:** 2023 оны батлагдсан нийт зардалд 2,548.4 сая төгрөгийн хүүний зардлыг Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөвлөсөн боловч санхүүжилтийн олголт хойшлогдон 05 дугаар сарын 18-ны өдөр хийгдэж, 6-12 дугаар сард нийт 842.6 сая төгрөгийн хүүний төлбөр төлсөн төлсөн. Санхүүгийн түрээсийн хүүний зардлыг тухайн жилийн зардлаар хүлээн зөвшөөрч татвар төлөхийн өмнөх ашгийг бууруулахаар тооцож, төлөвлөсөн боловч завсрын аудитын зөвлөмжийн дагуу тухайн хөрөнгө ашиглалтад ороогүй учир дуусаагүй үйлдвэрлэлээр хуримтлуулан бүртгэсэн болно.

**Бусад зардал:** Хэмнэлттэй болон төлөвлөгөөт хэмжээнд зарцуулагдсан болно. Нийт зардалд түлшний зардал 44 хувь, цахилгааны зардал 18 хувь, цалин, шимтгэлийн зардал 14 хувь, элэгдлийн зардал 15 хувь, бусад зардал 9 хувь эзэлж байна.



**4.4.АШИГ, АЛДАГДАЛ:**

Тайлант онд 20,627.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, төлөвлөгөөт ашгийг 2,256.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нийт орлого 103.0 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт зардал 3,132.8 сая төгрөгөөр буурсантай холбоотой.



**Дулааны эрчим хүчний өртөг:** Жилийн дундаж өртөг 44,373.6 төгрөг




ЭХЗХ-оос баталсан тариф төслийн санхүүжилт тооцоход 1 Гкал дулааны эрчим хүчний үнэ 65,220.6 төгрөг, төслийн санхүүжилтийг хасаж, үйл ажиллагааны орлогоор тооцоход 1 Гкал дулааны эрчим хүчний үнэ 34,419.9 төгрөг байна. 2023 оны тарифын саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд бэлтгэн хүргүүлж,

- 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 108 тоот тогтоолоор УБДС ТӨХК-д худалдах дулааны энергийн тарифыг 25,429.5 төг/Гкал буюу 6,074.0 төг/ГЖ, чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг 808,015.00 мянган төгрөг,
- ЭХЗХ-ны 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 228 тоот тогтоолоор 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс мөрдөх чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг 4,357,919.00 мянган төгрөг байхаар тус тус баталж, мөрдөн ажилласан.

**4.5.БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН 1 ТӨГРӨГТ  
НОГДОХ ЗАРДАЛ:**

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 0.68 төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 0.05 төгрөгөөр бууруулсан байна.




**4.6.НИЙТ АВЛАГА**

Нийт авлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,592.6 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 4,688.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь УБДС ТӨХК-аас жилийн эцсийн байдлаар 4,896.0 сая төгрөгийн борлуулалтын авлага үүссэнтэй холбоотой байна.

**Нийт авлагын мэдээ**

/сая төгрөгөөр/

№	Төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Өсөлт +, бууралт -	
					Өмнөх оны мөн үеэс	Төлөвлөснөөс
1	Борлуулалтын авлага	667.0	700.0	4904.1	4237.1	4204.1
2	Ажилчдаас авах авлага	15.7	10.0	8.1	-7.6	-1.9
3	Хувь хүнээс авах авлага	10.0	0.0	10.0	0.0	10.0
